

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДОТООД АУДИТЫН 2024 ОНЫ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын журам”, байгууллагын дотоод аудитын 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Санхүү, нийцлийн талаар

Дотоод аудитын 2024 оны төлөвлөгөөний дагуу санхүүгийн чиглэлээр 8, нийцлийн чиглэлээр 4, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 4, нийт 16 удаагийн төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж, үр дүнг илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулан, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Хяналт шалгалтыг төрлөөр нь ангилбал:

Д/д	Хяналт, шалгалтын төрөл	Хамрагдсан зохион байгуулалтын нэгжүүд	Хяналт шалгалтын тоо	Тайлбар
1.	Санхүү, үйл ажиллагааны чиглэлээр	Зүүн бүс дэх газар	1	төлөвлөгөөт
		Агаарын замын боомт хариуцсан газар	2	төлөвлөгөөт, гүйцэтгэлийн
		Санхүү, хангалт үйлчилгээний газар	1	төлөвлөгөөт
		Баруун бүс дэх газар	1	төлөвлөгөөт
		Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	1	төлөвлөгөөт
		Хойд бүс дэх газар	1	төлөвлөгөөт
		Худалдан авах ажиллагаа	1	төлөвлөгөөт
2.	Нийцлийн чиглэлээр	Агаарын замын боомт хариуцсан газар	2	төлөвлөгөөт, гүйцэтгэлийн
		Санхүү, хангалт үйлчилгээний газар	1	төлөвлөгөөт
		Худалдан авах ажиллагаа	1	төлөвлөгөөт
3.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд	Төв болон орон нутаг дахь нэгжүүд	4	төлөвлөгөөт

Дотоод аудитын хяналт шалгалтыг дэлгэрэнгүйгээр танилцуулбал:

- Байгууллагын даргын 05 дугаар сарын 01-ний өдрийн 01-02/21 дугаар удирдамжийн дагуу Зүүн бүс дэх газрын захиргаа, санхүүгийн 2024 оны нэгдүгээр улирлын үйл ажиллагаанд 05 дугаар сарын 06-наас 10-ны өдрүүдэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, үр дүнг удирдлагад 05 дугаар сарын 15-ны өдрийн 01-02/70 дугаар илтгэх хуудсаар;

- Байгууллагын даргын 05 дугаар сарын 17-ны өдрийн 01-02/27 дугаар удирдамжийн дагуу Агаарын замын боомт хариуцсан газрын зөрчил шалган шийдвэрлэлт, захиргаа, санхүү, нийцлийн чиглэлээр 2023 он, 2024 оны нэгдүгээр улирлын үйл ажиллагаанд 05 дугаар сарын 20-ноос 24-ний өдрүүдэд хяналт шалгалтыг хийж, үр дүнг удирдлагад 06 дугаар сарын 12-ны өдрийн 01-02/86 дугаар илтгэх хуудсаар;

- Байгууллагын даргын 06 дугаар сарын 19-ний өдрийн 01-02/35 дугаар удирдамжийн дагуу Санхүү, хангалт, үйлчилгээний газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд 06 дугаар сарын 24-нөөс 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд санхүүгийн болон нийцлийн аудитын хяналт шалгалтыг хийж, үр дүнг 07 дугаар сарын 05-ны өдрийн 01-08/10 дугаар илтгэх хуудсаар;

- Байгууллагын даргын 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01-02/48 дугаар удирдамжийн дагуу Баруун бүс дэх газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаа, Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2023, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд 09 дүгээр сарын 15-наас 21-ний өдрүүдэд хяналт шалгалт хийж, үр дүнг 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01-02/120 дугаар илтгэх хуудсаар;

- Байгууллагын даргын 10 дугаар сарын 01-ний өдрийн 01-02/51 дугаар удирдамжийн дагуу Агаарын замын боомт хариуцсан газрын захиргаа болон санхүүгийн үйл ажиллагаанд 10 дугаар сарын 08-ны өдөр гүйцэтгэлтийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, үр дүнг удирдлагад 10 дугаар сарын 14-ний өдрийн 01-02/128 дугаар илтгэх хуудсаар;

- Байгууллагын даргын 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01-02/58 дугаар удирдамжийн дагуу Хойд бүс дэх газрын захиргаа, санхүүгийн 2024 оны 01-03 дугаар улирлын үйл ажиллагаанд 11 дүгээр сарын 06-наас 09-ний өдрүүдэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, үр дүнг удирдлагад 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01-02/142 дугаар илтгэх хуудсаар;

- Байгууллагын даргын 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01-08/09 дугаар удирдамжийн дагуу Санхүү, хангалт үйлчилгээний газраас 2024 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд 11 дүгээр сарын 18-наас 22-ны өдрүүдэд дотоод аудит болон нийцлийн аудитын хяналт шалгалтыг хийж, үр дүнг 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01-08/22 дугаар илтгэх хуудсаар.

Дээрх хяналт шалгалтын хүрээнд Агаарын замын боомт хариуцсан газарт 01 дугаартай “Зөрчил, дутагдлыг арилгаж, ажлын хариуцлага сайжруулах тухай”, Хойд бүсийн газарт 03 дугаартай “Ажлын хариуцлага сайжруулах тухай” хугацаатай албан даалгаврыг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Түүнчлэн Санхүү, хангалт, үйлчилгээний газарт 2, Баруун бүс дэх газарт 1, Баян-Өлгий аймаг дахь хэлтэст 1, нийт 4 удаагийн зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин, биелэлтийг хангуулж ажиллалаа.

Байгууллагын даргын баталсан хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээний актад Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасны дагуу хяналт-шинжилгээ, нийцлийн аудит хийж, үр дүнгийн тайланг 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/795 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын зарим чиг үүрэг, нээлттэй байдалд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг удирдлагад танилцуулан, албан хаагчдад тайланг төрийн удирдлагын нэгдсэн систем “erp.e-mongolia.mn”-д мэдээлж ажиллалаа. Үүнд:

- байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр 8 зорилтын хүрээнд судалгаа, шинжилгээ хийн, удирдлагад 03 дугаар сарын 13-ны өдөр нэгдсэн тайланг;

- байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хүний нөөцийн бодлого, хөтөлбөр албан хаагчдад нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийн, 4 агуулгын хүрээнд боловсруулан асуумжийг дотоод сүлжээгээр дамжуулан 207 албан хаагч хамрагдсаныг нэгтгэж, удирдлагад 03 дугаар сарын 25-ны өдөр тайланг;

- 09 дүгээр сарын 09-ний өдрийн 02-08/06 дугаар удирдамжийн дагуу байгууллагын даргын 2024 оны эхний хагас жилд батлан гаргасан 259 тушаал, шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийн, удирдлагад 09 дүгээр сарын 24-ний өдөр тайланг;

- 2024 оны 03 дугаар улиралд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга болон шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ хийн, 10 дугаар сарын 30-ны өдөр 01-08/19 дугаар илтгэх хуудсаар удирдлагад тус тус танилцуулсан.

Хоёр. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Тайлант хугацаанд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 8 нэгжид 4 удаагийн удирдамжийн дагуу дотоод аудит хийж, үр дүнг 4 удаагийн илтгэх хуудсаар удирдлагад танилцуулан, 3 удаагийн зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулж, 4 удаа төрийн удирдлагын нэгдсэн систем ["erp.e-mongolia.mn"](http://erp.e-mongolia.mn)-д байршуулан нээлттэй мэдээллээ.

Шилэн дансны аудитыг хүснэгтээр харуулбал:

Д/д	Байгууллагын нэр	2023 он IV улирал	2024 он I улирал	2024 он II улирал	2024 он III улирал	Зөвлөмж
1	2	3	4	5	6	7
1.	Гадаадын иргэн, харьяатын газар	Удирдамжийн огноо, дугаар: 2024.01.12, 01-09/01	Удирдамжийн огноо, дугаар: 2024.04.08, 01-09/03	Удирдамжийн огноо, дугаар: 2024.07.02, 01-08/05	Удирдамжийн огноо, дугаар: 2024.10.04, 01-08/08	Зөвлөмжийн огноо, дугаар: 2024.01.23 09/04 2024.04.22 09/14 2024.10.10 08/39
2.	Агаарын замын боомт хариуцсан газар					
3.	Дорноговь аймаг дахь газар	Илтгэх хуудасны огноо, дугаар: 2024.01.19 01-09/01	Илтгэх хуудасны огноо, дугаар: 2024.04.17 01-09/03	Илтгэх хуудасны огноо, дугаар: 2024.07.05 01-08/09	Илтгэх хуудасны огноо, дугаар: 2024.10.10 01-08/17	Төрийн удирдлагын нэгдсэн систем "erp.e-mongolia.mn" -д байршуулсан огноо: 2024.01.26 2024.04.22 2024.07.08 2024.10.16
4.	Хойд бүс дэх газар					
5.	Өмнөд бүс дэх газар					
6.	Баруун бүс дэх газар					
7.	Зүүн бүс дэх газар					
8.	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс					

Гурав. Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний аудитын газрыг мэдээ, мэдээллээр хангаж ажилласан талаар

Хууль зүй, дотоод хэргийн яаманд аудитын тайлан, мэдээг албан бичгээр болон "э-мэйл" хаягаар хүргүүлэн, Үндэсний аудитын газар, Хууль зүй, дотоод хэргийн яамыг мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа. Үүнд:

- аудитын 2023 оны жилийн эцсийн тайланг 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/173 дугаар албан бичгээр;

- шилэн дансны тухай хуулийн 2024 оны I улирлын хэрэгжилтийн тайланг 04 дүгээр сарын 12-ны өдөр tumurochir@mojha.gov.mn хаягаар, II улирлын хэрэгжилтийн тайланг 07 дугаар сарын 03-ны өдрийн 01/1364 дугаар, III улирлын хэрэгжилтийн тайланг 10 дугаар сарын 14-ний өдрийн 01/2020 дугаар албан бичгээр;

-аудитын 2024 оны хагас жилийн төлөвлөгөөний биелэлт болон Үндэсний аудитын газрын 2023 оны санхүүгийн аудитаар илэрсэн байгууллагад холбогдох зөрчлийг арилгах зөвлөмжийн хэрэгжилтийг 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/1367 дугаар, 01/1376 дугаар албан бичгээр;

- байгууллагын 2024 онд эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар 19-ний өдөр байгууллагын даргаар батлуулан 12 дугаар сарын 25-ны өдрийн 09/2274 дугаар албан бичгээр, тус төлөвлөгөөний 2024 оны эхний хагас жилийн биелэлт, эрсдэлийн үнэлгээний тайланг 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/1365 дугаар албан бичгээр, жилийн эцсийн биелэлт, эрсдэлийн үнэлгээний тайланг 11 дүгээр сарын 27-ны өдрийн 08/2342 дугаар албан бичгээр.

Дөрөв. Бусад асуудлаар

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын хэсгийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдийн элэгдлийн хугацаа дууссан үндсэн хөрөнгийн талаар, 2024 оны 03 дугаар сарын 29, 04 дүгээр сарын 01, 04 дүгээр сарын 19-ний өдрүүдэд хугацаа дууссан эм боох материал, бичиг хэрэг, бусад хангамжийн материал, нормын хувцас актлах, тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэх талаар, 10 дугаар сарын 17-ны өдөр тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмжийг актлах, балансаас балансад шилжүүлэх талаар хэлэлцсэн хуралдаанд хэлтсийн дарга, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн нар оролцлоо.

Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын худалдан авах бодлогын хэлтэстэй хамтран Хууль зүй, дотоод хэргийн яаманд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр, мөн “Захиргааны хэм хэмжээний акт ба хүний эрх сэдэвт хэлэлцүүлэгт” 04 дүгээр сарын 24-ний өдөр, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын нэгдсэн системийн танилцуулга” хэлэлцүүлэгт 10 дугаар сарын 01-ний өдөр, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, тайлагнал” сэдэвт цахим сургалтад 10 дугаар сарын 07-ны өдөр хэлтсийн албан хаагчид тус тус оролцсон.

-----oOo-----